

## 2014 ОНЫ 6 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 07 дугаар сарын 17

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2014 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2014.06.01	Нэмэгдсэн	Хасагдсан	/тоогоор/
					2014.06.30
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	254			254
3	Даатгалын төлөөлөгч	3370	36	7 <sup>2</sup>	3399
4	Даатгалын зуучлагч	21	3 <sup>3</sup>		24
5	Даатгалын хохирол үнэлэгч	17			17
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	77			77
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	7			7
10	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	9			9

<sup>1</sup>Хорооны даргын 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 183 дугаар тушаалаар “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК-ийн 16 иргэнд, Хорооны даргын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 187 дугаар тушаалаар 19 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалаар “Гэр даатгал” ХХК-ийн 7 иргэний даатгалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

<sup>3</sup>Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 196 дүгээр тогтоолоор “Соёмбо Ай Би” ХХК-д, Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 197 дугаар тогтоолоор “Худалдаа хөгжлийн банк” ХХК-д 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Ваясню солюшн” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2014 оны 06 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.06.30 /сарын дүн/	2014.06.30 /өссөн дүн/
----------	---------------------------	---------------------------

Даатгалын нийт хураамж	13 901 897 664,92	51 553 594 157,46
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	2 895 012 728,17	10 945 460 186,04
Олгосон нийт нөхөн төлбөр	2 810 028 999,60	15 174 425 199,04
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	939 155 605,82	6 153 483 918,82
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	2 519,00	14 978,00
Давхар даатгалд төлсөн хураамж	5 201 147 732,82	17 869 665 218,17
Байгуулсан даатгалын гэрээний тоо	100 333,00	645 645,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	52 513,00	231 229,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	72 425,00	295 561,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1 298 945 049 164,22	5 832 657 180 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	154 347 554,23	74255828,00

2014 оны 06 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 51553.6 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 10945.5 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 15174.4 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 6153.5 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа өссөн дүнгээр 29.4 хувь болсон бөгөөд сарын дүнгээр 23.1 хувь байна.

Өмнөх оны мөн үетэй дээрх үзүүлэлтүүдийг харьцуулахад даатгалын хураамжийн орлого 13314.4 сая төгрөгөөр буюу 1.3 дахин, жолоочийн хариуцлагын даатгал 2882.2 сая төгрөгөөр буюу 1.4 дахин, олгосон нөхөн төлбөр 2674.3 сая төгрөгөөр буюу 1.2 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 1303.9 сая төгрөгөөр буюу 1.2 дахин тус тус нэмэгдсэн байна.

Ердийн даатгалын компаниудын 2014 оны 06 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Монгол даатгал” ХХК-ийн даатгалын 5832.7 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Мөн хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 68.1 сая төгрөгийг олгосон байна.

### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2014/06/30 сарын дүн	2014/06/30 өссөн дүн
Даатгалын нийт хураамж	147 898 975,00	707 706 702,38
Олгосон нийт нөхөн төлбөр	34 517 675,00	235 708 277,00
Давхар даатгалд төлсөн хураамж	333 568,00	4 584 069,00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	135,00	181,00
Хугацаат амьдралын даатгал	133	141

Насан туршийн даатгал	0,0	5,00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	1,00	13,00
Тэтгэврийн даатгалд	0,00	4,00
Орон сууцны даатгалд	0,00	1,00
Эрүүл мэндийн даатгал	0,00	17,0
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ	0,00	10,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	113 849 682,00	3 495 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	8 000 000,00	8 000 000,00

Урт хугацааны даатгагч 2014 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 707.7 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 228.6 сая төгрөгөөр буюу 1.4 дахин, нөхөн төлбөр 158.8 сая төгрөгөөр буюу 3.1 дахин нэмэгдсэн байна. Даатгалын хохирлын харьцаа 33.3 хувьтай байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

Үзүүлэлт	2014.06.30 /сарын дүн/	2014.06.30 /өссөн дүн/
Нийт орлого	120 690 934 051,52	307 718 594 605,49
Даатгалын зуучлагчийн орлого	335 286 749,84	1 342 453 267,30
Үүнээс: Сайн дурын даатгал	92 934 851,17	471 371 701,74
Албан журмын даатгал	239 485 381,07	856 112 390,47
Даатгуулагчаас зуучлагчаар дамжин төлсөн даатгалын хураамж	717 969 827,83	3 432 950 542,23
Зуучилсан даатгалын гэрээний тоо	23 273,00	82 717,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	9 923 806 130,00	27 541 474 224,97

2014 оны 06 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 120690.9 сая төгрөгийн нийт орлоготой, 335.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 71.0 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Эм жи ай би” ХХК, “Эс би ай эс” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

Үзүүлэлт	2014.06.30 /сарын дүн/	2014.06.30 /өссөн дүн/
Нийт орлого	130 374 944,86	535 138 554,30
Даатгалын хохирол үнэлгээний орлого	27 786 468,63	267 698 818,34

Үүнээс: Сайн дурын даатгал	12 874 418,09	82 028 200,64
Албан журмын даатгал	26 645 450,54	182 304 017,70
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	2 007,00	13 318,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	33 397 200,00	33397200.00

2014 оны 06 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 27.8 сая төгрөгийн хохирол үнэлгээний орлоготой ажилласан байна. Үүнээс 46.2 хувийг сайн дурын, үлдсэн хувийг албан журмын даатгалын хохирлын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Бест эстимэйт” ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 33.4 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

#### Бусад

Хорооны 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК-ийн, Хорооны 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор “Мандал даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг тус тус зөвшөөрсөн байна.

Хорооны 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор “Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

#### ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС